




Оксфордын
уншлагын
мог

Эрдэнэсийн авгар



Родерик Хант
Алекс Бричта



Долоо хоног бүр хатагтай Мей зарим хүүхдүүдийг усан санд авч очдог байв. Хүүхдүүд маш сайн сэлдэг болж, тэд ч хатагтай Мейтэй хамт явах дуртай болжээ.




Хүүхдүүд усанд сэлэлтийн шалгалт өгч байв.

-Одоо эхлэх цаг боллоо. Хэн эхлэх вэ? гэхэд,

-Би эхэлье гэж Надим хэлэв.



Биф, Чип, Вильма, Надим нар ус уруу үсрэн оров. Ус бүлээхэн байлаа. “Чөлөөтэй яваарай” гэж хатагтай Мей хэлэв.



Тэд хойшоо урагшаа арван тойрог сэлэх ёстой байв. Энэ сэлэлтэнд Вильма түрүүлж, Биф Надим хоёр дараа нь оров.



Энэ сэлэлт Чипийн хувьд хэцүү байв.
- Алив ээ, Чип яваарай! Битгий зогс,
энэ сүүлчийн тойрог гэж хатагтай Мей
хэлэв. Тэгээд Чип сэлж очин, бүгд
баярлацгаалаа.




Дараагийн өдөр нь тэд усан сангийн
ёроол уруу шумбан, тоосгыг дээш нь
гаргаж ирэх ёстой байв.

Changing Rooms



Бүх хүүхдүүд сэлэлтийн шалгалт өглөө.
Хатагтай Мей их баяртай байв.

-Бүгд сайн байна гэж тэр хэлэв.
Хүүхдүүд ч баяртай байлаа.




Биф Чип хоёр энэ сэлэлтийн шалгалтын талаар аав ээж хоёртоо хэлж, аав ээж хоёр нь ч их баяртай байв.



Аав ээж хоёр нь ч тэдэнд зориулж бэлэг
бэлджээ. Биф Чип хоёр үүнийг хараад,
- Энэ юу вэ? гэж асуув.



- Энэ чинь загасны аквариум байна шүү дээ, ямар гоё бэлэг вэ! гэж Биф хэлэв. Бүгд аквариумд сэлэх загасыг харж байв.




- Үүнд илүү олон загас хийсэн ч болно гэж аав нь хэлэхэд,
- Маргааш дэлгүүр явж загас авцгаанаа гэв.



Маргааш аав нь тэднийг загас худалдаалдаг дэлгүүрт авчрав.


- Ямар гоё дэлгүүр вэ, энэ загаснуудыг хараач! гэж Биф хэллээ.



Тэнд том жижиг загаснууд байв.
Киппер харин том загасанд дуртай.

Аав нь:

- Шилийг нь битгий тогш, загаснууд
үүнд дургүй гэв.



Аав нь хэдэн загас нэмж аваад, аквариумын ёроолд хэдэн чулуу, хөлөг онгоц, бас нэг жижиг авдар нэмж тавьсан байлаа.



Вильма Надим хоёр тэдний загасны аквариумыг үзэхээр ирэв. Тэгээд Вильма:

- Ямар гоё харагдаж байна аа, би энд сэлмээр л байна гэлээ.




Тэд Бифийн өрөөнд очоод, Чип шидэт
түлхүүрийг барин гүйхэд түлхүүр ч туяарч
эхлэв. Биф:

- Адал явдлын аялал эхэллээ гэв.



Ид шид ажиллаж эхлээд тэднийг шинэ адал явдалд аваачив. Энэ бол өмнөхөөсөө огт өөр адал явдал байлаа.



Ид шид тэднийг усан доор аваачжээ.
Хүүхдүүд усны шил, сэлүүр, агаарын
савтай болсон байв. Тэд усан доор сэлж
байлаа.



Хүүхдүүд өмнө нь хэзээ ч ийм олон загас харж байгаагүй бөгөөд тэд бүгдээрээ өөр өөр өнгөтэй байв.

- Энэ усан сангаас хавьгүй дээр юм аа гэж Чипийг хэлэхэд, Вильма:


- Би загас шиг л байна гэв.



Усан дотор сэлэх нь хүүхдүүдэд таатай
байлаа. Загаснуудын сэлэхийг харах ч
сайхан байв.




Чип Надим хоёр усны ёроолд аварга хясааг өргөж үзэв. Биф цэлцгэнүүр загасыг харсан боловч тэр нь сэлэхгүй байлаа.



Хүүхдүүд усан доорх хөлөг онгоцыг харлаа. Энэ бол маш хуучин, усан доор их удаж байгаа онгоц байв.



Гэвч усан онгоц их аюултай харагдаж байсан учраас Вильма тийшээ очихыг хүсэхгүй байлаа.



Тэнд нэгэн наймаалж харагдлаа.
Наймаалж авдарны таган дээр сууж
байсан учраас авдран дотор юу байгааг
тэд харж чадсангүй.



Тэд наймаалжийг хийн бөмбөгөөр
үлээлгэж холдуулаад авдран доторхийг
үзэх гэж яарцгаав.



Хүүхдүүд авдрыг онгойлгож хартал юу
байсан гэж санана ...


Эрдэнэсийн авдар ... Авдар дүүрэн алт
байлаа.



Биф Вильма хоёр авдрыг түлхэн алтыг асгахад Надим хүзүүний зүүлт, Вильма харин алтан цом авав.



Биф Надим хоёр Чип Вильма хоёрыг анзаарч харсан ч үгүй, алтнаас харцаа салгаж чадахгүй байв. Гэтэл аварга загас ирж байлаа.




Чип Вильма хоёр тэр хоёрт аварга загас
ирж байгааг хэлж чадахгүй учраас тэднийг
татаж, аварга загасны зүг заалаа.



Хүүхдүүд айцгаан, сэлээд л байв,
сэлээд л байв.

Гэсэн ч аварга загас тэдний ард тулж
ирлээ.

Яг тэр үед шидэт түлхүүр туяарч
эхлэв.



Шидэт түлхүүр тэдний адал явдлыг дуусгасан байв.

- Хөөх, ямар гоё адал явдал вэ? Тэр эрдэнэсийн авдар манай загасны аквариумынхтай адилхан байсан гэж Биф хэлэв.



Хүүхдүүд аквариумыг харахаар ирхэд,
түүн доторх авдар хажуу тийшээ унасан
байлаа. Надим түүнийг хараад гайхан,
- Түүнийг хараач! Хэн үүнийг ингэсэн
юм бол оо? гэхэд,
- Энэ бол ид шид гэж Биф хариулав.



Оксфордын
уншлагын
мог

Шатлал 6
Түүхүүд

Эргэнэсийн авгар



Хүүхдүүд усан доорхи аялалд явав.



Хэвлэн нийтлэлийг
Интерпресс ХХК



Дэлхийн банктэй хамтран хэрэгжүүлж буй
«Хөдөөгийн боловсролыг дэмжих
(READ) төсөл»-ийн хүрээнд хэвлэв.
Худалдахыг хориглоно.